

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Өвөрхангай аймгийн “Өв агро гурил тэжээлийн үйлдвэр” ОНӨ ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨВА-2026/12/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn

Өвөрхангай аймаг,
Арвайхээр сум
2026 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер: П.Хорлоосүрэн

Утас: 70323833 Цахим хаяг: Khorloosuren.p.audit@gov.mn

Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг

Утас: 70323108 Цахим хаяг: erdenetsetsegb@audit.gov.mn

Чадварлаг Аудит ХХК-ийн захирал: Д.Рэнцэнханд

Утас: 99200034 Цахим хаяг: chadvarlagAudit@gmail.com

Аудитор: П.Сосорбурам

Утас: 94422277 Цахим хаяг: sosorburampurev3@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ӨВА 2026/12
/НА-СТА-ОНӨҮГ

Нэг.Хараат бус аудиторын дүгнэлт



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.14 № 135
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4,Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Өвөрхангай аймгийн “Өв агро гурил тэжээлийн үйлдвэр” ОНӨ ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Өв агро гурил тэжээлийн үйлдвэр” ОНӨ ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болн

Асуудлыг онцолсон зүйл

“Өв агро гурил тэжээлийн үйлдвэр” ОНӨ ХХК нь 2025 онд 326.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, борлуулалтын өртөгт 242.3 сая төгрөг, ерөнхий удирдлагын зардалд 52.6 сая төгрөгийг зарцуулж, орлогын татвар 1.6 сая төгрөг төлөхөөр тооцож 29.9 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг.

Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно. Тайлант онд “Өв агро гурил тэжээлийн үйлдвэр” ОНӨ ХХК нь оны эхэнд 53,5 сая төгрөгийн өвсний үлдэгдэлтэйгээс, 260.6 сая төгрөгийн өвс хураан авч,242.3 сая төгрөгийн өвс худалдаж 71.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Бусад мэдээллийн талаар 2025 онд “Өв агро гурил тэжээлийн үйлдвэр” ОНӨ ХХК-н Төлөөлөн удирдах зөвлөлийн удирдлага, гишүүд өөрчлөгдсөн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

5225051300

D:\Auditin gazar\baiguullagin dotood barimt\A4

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ	0.00	0.00
1.1	Эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	827,541.00	24,133,710.42
1.1.2	Дансны авлага	15,967,760.00	15,967,760.00
1.1.6	Бараа материал	88,881,337.36	105,988,180.26
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	105,676,638.36	146,089,650.68
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.1	Үндсэн хөрөнгө	480,010,527.58	431,187,937.05
1.2.2	Биет бус хөрөнгө	350,269,786.31	350,137,786.31
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	830,280,313.89	781,325,723.36
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	935,956,952.25	927,415,374.04
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.1.1	Дансны өглөг	78,799,080.00	78,799,080.00
2.1.1.3	Татварын өр	1.00	1,574,221.14
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	77,018,188.00	37,018,188.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	155,817,269.00	117,391,489.14
2.2	Өр төлбөрийн нийт дүн	155,817,269.00	117,391,489.14
2.3	Эздийн өмч	0.00	0.00
2.3.1	Төрийн өмч	707,841,295.10	707,841,295.10
2.3.9	Хуримтлагдсан ашиг	72,298,388.15	102,182,589.80
2.3.11	Эздийн өмчийн дүн	780,139,683.25	810,023,884.90
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	935,956,952.25	927,415,374.04

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	311,039,000.00	326,361,940.00
2	Борлуулалтын өртөг	284,291,105.64	242,269,193.90
3	Нийт ашиг (алдагдал)	26,747,894.36	84,092,746.10
8	Бусад орлого	11,897,600.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	45,564,877.04	48,954,590.53
11	Санхүүгийн зардал	1,511,900.00	3,653,732.78
12	Бусад зардал	17,371,656.00	26,000.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (-25,802,938.68	31,458,422.79
19	Орлогын татварын зардал		1,574,221.14
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-25,802,938.68	29,884,201.65
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-25,802,938.68	29,884,201.65
24	Орлогын нийт дүн	-25,802,938.68	29,884,201.65

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	303,778,840.00	280,356,940.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний	291,881,240.00	280,356,940.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	11,897,600.00	0.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	303,665,264.00	217,050,770.58
1.2.1	Ажиллагчдад төлсөн	21,788,436.00	19,877,893.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	8,630,504.00	8,651,908.80
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	238,368,664.00	182,687,255.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	2,365,760.00	2,153,981.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	32,511,900.00	3,679,732.78
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн	113,576.00	63,306,169.42
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	40,000,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	40,000,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны	0.00	-40,000,000.00
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	113,576.00	23,306,169.42
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний	713,965.00	827,541.00
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн	827,541.00	24,133,710.42

2.4 Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	707,841,295.10	98,101,326.83	805,942,621.93
3	Залруулсан үлдэгдэл	707,841,295.10	98,101,326.83	805,942,621.93
5	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	-25,802,938.68	-25,802,938.68
9	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	707,841,295.10	72,298,388.15	780,139,683.25
11	Залруулсан үлдэгдэл	707,841,295.10	72,298,388.15	780,139,683.25
13	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	29,884,201.65	29,884,201.65
17	2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	707,841,295.10	102,182,589.80	810,023,884.90

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2025оны			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үндсэн болон нэмэгдэл цалин	37,915,200.00	35,541,620.00	2,373,580.00	93.74
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,739,400.00	4,465,382.50	274,017.50	94.22
ТУЗ-ийн зардал	1,600,000.00	1,800,000.00	(200,000.00)	112.50
Тээвэр, шатахуун	30,500,000.00	38,625,274.00	(8,125,274.00)	126.64
Санхүүгийн зардал	2,440,000.00	3,653,733.78	(1,213,733.78)	149.74
Аж ахуйн материал	20,760,000.00	26,936,617.40	(6,176,617.40)	129.75
Газрын түрээс	35,062,500.00	33,740,000.00	1,322,500.00	96.23
Үрийн зардал	105,000,000.00	52,443,299.00	52,556,701.00	49.95
Сэлбэг хэрэгсэлийн зардал	2,000,000.00	5,517,000.00	(3,517,000.00)	275.85
Бордоо	3,000,000.00		3,000,000.00	-
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	45,564,800.00	48,954,590.53	(3,389,790.53)	107.44
Техникийн түрээс		43,200,000.00	(43,200,000.00)	#DIV/0!
Бусад зардал	-	26,000.00	(26,000.00)	#DIV/0!
Орлогын татварын зардал		1,574,221.14	(1,574,221.14)	#DIV/0!
Байгууллагын нийт зардал	288,581,900.00	296,477,738.35	(7,895,838.35)	102.74
Эхний үлдэгдэл	16,795,200.00		16,795,200.00	-
Борлуулалтын орлого	300,000,000.00	326,361,940.00	(26,361,940.00)	108.79
ОРЛОГЫН ДҮН	316,795,200.00	326,361,940.00	(9,566,740.00)	103.02
АШИГ+ АЛДАГДАЛ-	28,213,300.00	29,884,201.65	(1,670,901.65)	105.92

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 41.6 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 41.6 сая төгрөгийн алдааг залруулав.

Аудитаар нийт 55.9 сая төгрөгийн зөрчил² илэрснээс 55.9 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэв .

3.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт бичигдээгүй.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ӨВА-2026/12/НА-СТА-НӨҮГ

3.2 Албан шаардлага

1. Илрүүлэлт:

Албан шаардлага гараагүй болно.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг зөвлөмжид харуулав. Үүнд:

1. Шилэн дансны хуультай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд шилэн дансны сайтад Хөдөө аж ахуйг дэмжих санд төлсөн техник хэрэгсэлийн үнэ 40 000 000.00 төгрөгийн 1 гүйлгээг шилэн дансанд дутуу мэдээлсэн.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны мэдээллийг цахим сайтад мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх, мэдээллийг бүрэн сайтад байршуулсан эсэхэд хяналт тавьж ажиллах талаар

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-т “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ”. гэсний дагуу зөвлөмжийн төлөвлөгөөг гарган, Зөвлөмжийн биелэлтийг албан бичгээр нотлох баримтын хамт Төрийн аудитын газрын FAS системд оруулж, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх зөвлөмжийг хүргүүлж байна.

Цаашид анхаарвал зохих асуудлыг зөвлөмжид харуулав. Үүнд:

2.Өр, авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн авлагын үлдэгдэл 15 967 760.00 төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Авлагыг бүрэн барагдуулж, өглөгө, авлагагүй ажиллах

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-т “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ”. гэсний дагуу зөвлөмжийн төлөвлөгөөг гарган, Зөвлөмжийн биелэлтийг албан бичгээр нотлох баримтын хамт Төрийн аудитын газрын FAS системд оруулж, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх зөвлөмжийг хүргүүлж байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Хөдөө аж ахуйг дэмжих сангаас зээлийн гэрээгээр авсан техник, тоног төхөөрөмжийн төлбөр 40,000,000.00 төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээгээр тайлагнасан,	1	40,000.0			1	40,000.0	1	40,000.0				
Тайлант онд ХХК нь 31,458,432.79 төгрөгийн ашигтай ажилласан . Татварын хуулийн дагуу орлогын албан татвар 1,574,221.14 төгрөгийг тооцож тайлагнаагүй .	1	1,574.2			1	1,574.2	1	1,574.2				
Дүн	2	41,574.2			2	41,574.2	2	41,572.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өмнөх оны санхүүгийн тайлангийн авлагын үлдэгдэл 15,967,760.00 төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна	1	15,967.8					1	15,967.8				
Дүн	1	15,967.8			0	00.0	1	15,967.8				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Үүнээс		Төлбөрийн акт		Албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хөдөө аж ахуйг дэмжих санд төлсөн техник хэрэгсэлийн үнэ 40,000,000.00 төгрөгийн 1 гүйлгээг шилэн дансанд мэдээлээгүй.	1	40,000.0					1	40,000.0
Дүн	1	40,000.0					1	40,000.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	40,000.0					1	40,000.00

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2026 оны 3 дугаар сарын 13